



ЗАМЫН-ҮҮД ЧӨЛӨӨТ БҮСИЙН ЗАХИРАГЧИЙН ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 03 өдөр

Дугаар А/14

Улаанбаатар хот

Төлөвлөгөө батлах тухай

Чөлөөт бүсийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6, Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4, 6.1.8 дахь хэсэг, Хөдөлмөрийн дотоод журмын 5 дугаар зүйлийн 5.1.3 дахь хэсэг, “Замын-Үүд” чөлөөт бүсийн Захирагчийн “Төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Замын-Үүд” чөлөөт бүсийн “Ашиг сонирхлын зөрчил, авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2023 оны төлөвлөгөө”-г нэгдүгээр, “Төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах 2023 оны төлөвлөгөө”-г хоёрдугаар, “Мэргэшил мэдлэгийг дээшлүүлэх 2023 оны сургалтын төлөвлөгөө”-г гуравдугаар, “Дотоод хяналт зохион байгуулах 2023 оны төлөвлөгөө”-г дөрөвдүгээр, “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийн 2023 оны төлөвлөгөө”-г тавдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Төлөвлөгөөг хэрэгжүүлж, үр дүнг тайлагнаж ажиллахыг Гэрээ эрх зүй, хүний нөөцийн хэлтэс (Б.Ономаа)-т үүрэг болгосугай.


ЗАХИРАГЧИЙН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Ц.ГАНБАТ

00230061

“Замын-Үүд” чөлөөт бүсийн Захирагчийн
2023 оны 04 дүгээр сарын 03-ний өдрийн
М.И. тоот захирамжийн 1 дүгээр хавсралт



**“ЗАМЫН-ҮҮД” ЧӨЛӨӨТ БҮСИЙН АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧИЛ,
АВЛИГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2023 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ**


2023 оны 04 дүгээр сарын 03

Улаанбаатар хот

Д/д	Хийх ажил	Хөрөнгө санхүү	Хугацаа	Хариуцах эзэн	Хүрэх үр дүн
1	Албан хаагчдын хөрөнгө орлогын мэдүүлгийг зохих журмын дагуу хугацаанд нь гаргуулж, холбогдох тайлан мэдээг Авлигатай тэмцэх газар хүргүүлэн баталгаажуулах.	Шаардахгүй	2023 оны 02 сарын 15-ны дотор	ЭБАТ	Шинээр томилогдох ажилчдын хөрөнгө орлогын урьдчилсан мэдүүлгийг Авлигатай тэмцэх газарт хүргүүлэх. Хөрөнгө орлогын мэдүүлгийг цаг тухайд нь АТГ-ын www.meduuleg.iaac.mn сайтад шивүүлж, баталгаажилт хийлгэн холбогдох тайлан мэдээг тухай бүр бэлтгэн хүргүүлэх ажлыг зохион байгуулна.
2	Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд хувийн ашиг сонирхлыг зохицуулах ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиудын хэрэгжилтийг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах.	Шаардахгүй	2023 онд	ГЭЗХНХ	Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд хувийн ашиг сонирхлыг зохицуулах ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиудын алба хаагчдад ухуулан сурталчлан, мэдлэгийг дээшлүүлэх зорилготой хууль эрх зүйн эмхэтгэл, гарын авлага, ном товхимолоор нийт алба хаагчдыг хангаж, мэдлэгийг бататгахаар сорилын тест авч мэдлэгийг сайжруулна.
3	Авлигатай тэмцэх газрын сургалтын хөтөлбөрт хамрагдаж нийт албан хаагчдад төлөвлөгөөний дагуу сургалт зохион байгуулах	Шаардахгүй	2023 онд	ЭБАТ	Хөрөнгө орлогын мэдүүлэг болон ашиг сонирхлын зөрчлийн мэдүүлгийн талаар нийт ажилтан албан хаагч нарт сургалт зохион байгуулан явуулсан байна.

4	Чөлөөт бүсэд мөрдөгдөх дүрэм, журам, шийдвэрийг олон нийтэд ил тод мэдээллэх.	Шаардахгүй	2023 онд	ГЭЗХНХ, ГХХАМТХ	Чөлөөт бүсэд мөрдөгдөх дүрэм, журам, шийдвэрийн жагсаалтыг гарган байгууллагын цахим хуудсаар нийтэд ил тод мэдээлсэн байна.
---	---	------------	----------	--------------------	--

“Замын-Үүд” чөлөөт бүсийн Захирагчийн
2023 оны 04 дүгээр сарын 03-ний өдрийн
М/Н... тоот захирамжийн 2 дүгээр хавсралт



**“ЗАМЫН-ҮҮД” ЧӨЛӨӨТ БҮСИЙН ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ТӨРИЙН АЛБАН ХААГЧДЫН АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН БАТАЛГААГ
ХАНГАХ 2023 ОНЫ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

2023 оны 04 дүгээр сарын 03


Улаанбаатар хот

Д/д	Авч хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт		Хариуцах албан тушаалтан
		Хугацаа	Хөрөнгө, санхүү	
1	Төрийн албаны тухай хууль, Чөлөөт бүсийн тухай хууль, Засгийн газрын 2015 оны 126 дугаар тогтоол, “Монгол, Хятад хоёр улс Замын-Үүд, Эрээний эдийн засгийн хамтын ажиллагааны бүс байгуулах тухай” хоёр улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн хэрэгжилтийг хангах хүрээнд ажлын албыг батлагдсан орон тоогоор ажиллуулах, төрийн албаны салбар зөвлөлтэй хамтран тусгай шалгалтын сонгон шалгаруулалтыг зохион байгуулах, ажилчдын ажлын ачааллыг тэнцвэржүүлэх ажлуудыг тухай бүр хийж гүйцэтгэх.	I-IV улиралд	Шаардахгүй	ГЭЗХНХ
2	Албан хаагчийг албан тушаалын тодорхойлолтод заасан ажиллах нөхцөл, боломж, ажлын байр, тавилга, багаж, тоног төхөөрөмж, техник хэрэгслэл, нормын хувцас, хөдөлмөр хамгааллын хувцасаар хангана.	I-IV улиралд	Зардлыг тухай бүр шийдвэрлэнэ.	ГЭЗХНХ, БСХ
3	Албан хаагчдын ажлын үр дүн, үнэлгээ, ажилласан жил, ур чадварыг харгалзан зэрэг дэв, цалин нэмэгдүүлэх асуудлыг Үнэлгээний багийн хурлаар хэлэлцэн Удирдлагад уламжлан шийдвэрлүүлэх.	I-IV улиралд	Шаардахгүй	ГЭЗХНХ
4	Төвлөрсөн халаалтад холбогдоогүй орон сууц, гэрт амьдардаг алба хаагчдад түлээ нүүрсний хөнгөлөлт олгох, албан хаагчдын нийгмийн баталгааг хангах үүднээс зуслангийн газартай болох ажлыг нэгдсэн журмаар өөрсдийнх нь идэвхтэй оролцоотойгоор зохион байгуулах.	I-IV улиралд	Шаардахгүй	ГЭЗХНХ

5	Алба хаагчдыг спорт биеийн тамираар хичээллүүлж, идэвхтэй хөдөлгөөнөөр бие бялдрыг чийрэгжүүлж, уралдаан тэмцээнд оролцуулах, амжилт гаргасан алба хаагчдыг шагнаж урамшуулах.	I-IV улирал	Зардлыг тухай бүр шийдвэрлэнэ.	ГЭЗХНХ
---	--	-------------	--------------------------------	--------

/Тайлбар: ГЭЗХНХ, БСХ/

“Замын-Үүд” чөлөөт бүсийн Захирагчийн
2023 оны 04 дүгээр сарын 03-ний өдрийн
М/141 тоот захирамжийн 5 дүгээр хавсралт



**“ЗАМЫН-ҮҮД” ЧӨЛӨӨТ БҮСИЙН ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ТӨРИЙН АЛБАН ХААГЧДЫН МЭРГЭШИЛ, МЭДЛЭГИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ
2023 ОНЫ СУРГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**


2023 оны 04 дүгээр сарын 03

Улаанбаатар хот

Д/д	Сургалтын сэдэв	Шалгуур үзүүлэлт		Хариуцах хэлтэс, ажилтан	Оролцох албан хаагчид
		Хугацаа	Хөрөнгө санхүү		
НЭГ. БАЙГУУЛЛАГЫН ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГААГААР ЗОХИОН БАЙГУУЛАХ СУРГАЛТ					
1	Албан хаагчдын эрх зүйн боловсролыг дээшлүүлэхэд зайлшгүй мэдэж байх ёстой хууль тогтоомжийн жагсаалт гарган мэдээллийн цагаар шатлалтайгаар танилцуулах.	2023 онд	Шаардахгүй	ГЭЗХНХ	Нийт албан хаагчид
2	Архив, албан хэрэг хөтлөлтийг сайжруулах талаар нийт ажилтан, албан хаагчдад ажлын байрны сургалт зохион байгуулах.	II улирал	Шаардахгүй	ГЭЗХНХ	Нийт албан хаагчид
3	Ажилтан албан хаагчдын мэргэжил, мэргэшлийн дагуу зохиогдох сургалт, семинар, туршлага судлах, ажлуудыг тухай бүр зохион байгуулан ажиллах.	2023 онд	Зардлыг тухай бүр байгууллагын сургалтын төсвөөс шийдвэрлэнэ.	ГЭЗХНХ, ГХХАМТХ, БСХ	Нийт албан хаагчид
ХОЁР. ГАДНЫ БАЙГУУЛЛАГАТАЙ ХАМТРАН ЗОХИОН БАЙГУУЛАХ СУРГАЛТ					

4	Удирдлагын академийн Төрийн албаны сургуульд богино хугацааны анхан, дунд шатны сургалт, Төрийн албан хаагчийг мэргэшүүлэх дэс түшмэл, ахлах, эрхэлсэн түшмэлийн багц сургалтуудад холбогдох албан хаагчдыг хамруулах.	I-IV улирал	Улсын төсвийн хөрөнгөөр, хувь хүний зардлаар	ГЭЗХНХ	Зохих албан хаагчдыг хамруулна.
5	Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчилан таниулах, хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх талаар сургалт зохион байгуулах.	2023 онд	Зардлыг тухай бүр байгууллагын сургалтын төсвөөс шийдвэрлэнэ.	АТГ, ГЭЗХНХ, ЭБАТ	Нийт албан хаагчид

“Замын-Үүд” чөлөөт бүсийн Захирагчийн
2023 оны 04 дүгээр сарын 03-ний өдрийн
11/11 тоот захирамжийн 4 дүгээр хавсралт



“ЗАМЫН-ҮҮД” ЧӨЛӨӨТ БҮСИЙН ДОТООД ХЯНАЛТ, ШАЛГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ 2023 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ


2023 оны 04 дүгээр сарын 03

Улаанбаатар хот

Д/д	Хяналт шалгалтын ажиллагаа	Хугацаа	Хариуцах хэлтэс
1. Захирагчийн Ажлын албаны дотоод үйл ажиллагаанд тавих хяналт шалгалт.			
1	Захирагчийн Ажлын албаны хэмжээнд мөрдөгдөх дүрэм журмуудыг хууль тогтоомжид нийцүүлэн гаргах, гаднаас ирсэн болон бусад байгууллагад явуулсан бичиг баримтанд тавих хяналт.	I-IV улирал	ГЭЗХНХ
2	Архив, бичиг хэргийн бүртгэл хөтлөх, хэрэгжүүлэх, сахилга дэг журам, ажлын цаг ашиглалтад тавих хяналт.	I-IV улирал	ГЭЗХНХ
2. Нэгжүүдийн үйл ажиллагаанд тавих хяналт шалгалт;			
3	Захирагчийн Ажлын албаны нэгжүүдийн үйл ажиллагааны хэвийн нөхцөлийг хангах, шаардлагатай арга хэмжээ авч ажиллах үүргийн биелэлтэд тавих хяналт.	I-IV улирал	ГЭЗХНХ
4	Нэгжүүдийн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэнд хяналт тавих, дүгнэх.	II, IV улирал	ГЭЗХНХ
5	Албан хаагчдын гүйцэтгэж буй ажлын чанартай уялдуулан ажлын бүтээмжийн талаар байнгын хяналт тавьж үр дүнг тооцох.	I-IV улирал	ГЭЗХНХ
6	Ажлын ирц, ажлын цаг ашиглалтын талаар цагийн бүртгэл хариуцсан мэргэжилтэнтэй хамтарсан шалгалт хийж, ажлын бүтээмжийг бодитоор үнэлж байгаа байдалд хяналт тавих.	I-IV улирал	ГЭЗХНХ
7	Гадаад харилцаа, мэдээ мэдээлэл бэлтгэх үйл ажиллагаанд тавих хяналт	I-IV улирал	ГХХАМТХ, ГЭЗХНХ
3. Өмч хөрөнгө, санхүүгийн бүртгэл, тооцооны үйл ажиллагаанд тавих хяналт шалгалт;			

8	Захирагчийн Ажлын албаны болон чөлөөт бүсийн өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, ашиглалтын байдалд хяналт тавих.	II, IV улирал	БСХ, ГЭЗХНХ
9	Төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэл, зардлын нормын мөрдөлтөд хяналт тавих.	II, IV улирал	БСХ, ГЭЗХНХ
10	Санхүүгийн анхан шатны баримтын бүрдүүлэлт болон нягтлан бодох бүртгэлийн аргачлал, заавар, журам, стандартын хэрэгжилтэнд хяналт тавих.	I-IV улирал	БСХ, ГЭЗХНХ
11	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн талаарх хяналт шалгалт	II, IV улирал	ГЭЗХНХ
4. Хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд тавих хяналт шалгалт.			
12	Тухайн жилд хөрөнгө оруулалтаар хийгдэх ажлын болон төсөл сонгон шалгаруулалтын бичиг баримтын бүрдэл, үйл явцад хяналт тавих.	I-IV улирал	ХОХБХ, ГЭЗХНХ
13	Газар эзэмших, ашиглах эрх олгох үйл ажиллагаанд тавих хяналт	I-IV улирал	ДБХГХХ
5. Хөдөлмөрийн дотоод журмын биелэлтэд тавих хяналт шалгалт.			
14	Гүйцэтгэлийн төлөвлөгөө, хөдөлмөрийн гэрээгээр болон албан тушаалын тодорхойлолтод заасан ажил үүргээ хангалтгүй биелүүлсэн, байгууллагад мөрдөж байгаа дүрэм, журам зааврыг зөрчсөн, хугацаатай үүрэг даалгаврыг хугацаанд нь биелүүлээгүй албан тушаалтны гаргасан зөрчилд хяналт шалгалтын ажиллагаа явуулж материалыг нэгтгэн Захирагчид танилцуулах.	I-IV улирал	ГЭЗХНХ
6. Байгууллагын бусад хяналт шалгалт.			
15	Дотоод хяналт шалгалтын бүртгэл мэдээллийн сан бүрдүүлж архивт шилжүүлэх.	IV улирал	ГЭЗХНХ
16	Дотоод хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлын талаар албан хаагчдад зөвлөмж өгч сургалт зохион байгуулах.	III улирал	ГЭЗХНХ

“Замын-Үүд” чөлөөт бүсийн Захирагчийн
2023 оны 04 дүгээр сарын 03-ний өдрийн
4/14 тоот захирамжийн 5 дүгээр хавсралт



**“ЗАМЫН-ҮҮД” ЧӨЛӨӨТ БҮСИЙН ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ,
ЭРҮҮЛ АХУЙН ЗӨВЛӨЛИЙН 2023 ОНЫ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

2023 оны 04 дүгээр сарын 03

Улаанбаатар хот

Д/д	Хийх ажил	Хөрөнгө санхүү	Хугацаа	Хариуцах эзэн
1	Ажилд шинээр томилогдсон ажилтан, албан хаагчдад хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн урьдчилсан зааварчилгааг тухай бүр өгч, тэмдэглэл хөтлөн баталгаажуулах.	Шаардахгүй	Тухай бүр	ХАБЭА-н зөвлөл
2	Ажилтан албан хаагчдад гүйцэтгэх ажил мэргэжлийн дагуу ажилтнуудад олгох ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслүүдийн зохистой хэрэглээнд хяналт тавьж ажиллах. Шаардлагатай тохиолдолд сургалт зохион байгуулах.	Шаардахгүй	Тухай бүр	ХАБЭА-н зөвлөл, БСХ
3	Чөлөөт бүсийн Мэргэжлийн албадын нэгдсэн байран дахь аюулгүй ажиллагаа, ажилтнуудын эрүүл ахуйн байдалд хяналт шинжилгээ хийж, гарсан зөрчил дутагдлыг арилгуулах, хөдөлмөр, теникийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм журмыг мөрдөж ажиллуулах арга хэмжээ авах.	Хуульд заассан хувь хэмжээгээр.	I-IV улирал	ХАБЭА-н зөвлөл
4	Чөлөөт бүсэд үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллагуудын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтантай хамтран аливаа үйл ажиллагааны үед аюул, осолгүй ажиллах, холбогдох хууль, дүрэм журмын хэрэгжилтэд хяналт тавих.	Шаардахгүй	Тухай бүр	ХАБЭА-н зөвлөл, БСХ

5	“Замын-Үүд” чөлөөт бүсийн Захирагчийн ажлын албаны Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг боловсруулан батлуулж, шаардлагатай тохиолдолд тодотгол хийх ажлыг зохион байгуулан ажиллах.	Шаардахгүй	” III улирал	ХАБЭА-н зөвлөл, БСХ
---	--	------------	--------------	---------------------

---oOo---